

Батлав: БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газрын дарга.....Б.Буяннэмэх

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн: “Алтайн хүдэр” ХХК-ийн Гүйцэтгэх захирал.....Б. Хулан



**АЛТАЙН ХҮДЭР ХХК**  
МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН КОМПАНИ

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН НУТАГ  
ДЭВСГЭРТ ОРШИХ “ТАЯН НУУР” ТӨМРИЙН ХҮДРИЙН  
ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.**

Үндсэн тусгай зөвшөөрлийн дугаар: MV-013527, MV-015377  
Нэмэлт тусгай зөвшөөрлийн дугаар: MV-017626, MV-017627  
Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: № 5095549

Хянасан: Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газрын Ахлах шинжээч.....Ц.Жаргалнэмэх.

Боловсруулсан: “Алтайн хүдэр” ХХК-ийн  
Байгаль орчны мэргэжилтэн.....Э.Золзаяа.

## АГУУЛГА.

1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1 Төслийн нэр.....	3
1.2 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллага.....	3
1.3 Төслийн зорилго.....	3
1.4 Төслийн байршил.....	3
1.5 Ордын үйлдвэрлэлийн нөөц.....	3
1.6 Уурхайн барилга, байгууламж.....	4
1.7 Дэд бүтэц.....	8
1.7.1 Зам харилцаа.....	8
1.7.2 Харилцаа холбоо.....	9
1.7.3 Цахилгаан хангамж.....	9
1.7.4 Усан хангамж.....	9
1.8 Ажиллах хүч.....	10
2.ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	10
2.1 Газар зүйн бүс, бүсчлэл.....	10
2.2 Цаг уур, уур амьсгалын тодорхойлолт.....	10
2.3 Гадаргын болон газрын доорх ус.....	10
2.4 Хөрсөн бүрхэвч.....	10
2.5 Ургамлан нөмрөг.....	11
2.6 Амьтны аймаг.....	11
2.7 Геологийн тогтоц.....	11
2.8 Говь-Алтай аймгийн Цээл сум.....	12
3.ҮЙЛДВЭРЛЭЛ, УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ.....	13
4. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	15
4.1 Агаарын чанар, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	15
4.2 Газрын гадарга, хэвлий, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	15
4.3 Хөрсөн бүрхэвч түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	15
4.4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	15
4.5 Ургамлан нөмрөг түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	15
4.6 Амьтны аймагт нөлөөлөх сөрөг нөлөөлөл.....	15
5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	
5.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй.....	18
6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
6.1. Агаарын чанар, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах.....	21
6.2 Газрын хэвлий, Хөрсөн бүрхэвч түүнд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах.....	22
6.3 Гадаргын болон газрын доорх ус, түүнд нөлөөлөх сөрөг нөлөөлийг бууруулах.....	23
6.4 Ургамлан нөмрөг түүнд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах.....	24
6.5 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах.....	24
7.НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	26
8.БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	27
9.НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	29
10. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	29
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	30
11. ХОГ ХАЯГДЛЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	34

12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	37
13. БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ.....	38
14. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	39

#### ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 Таяннуурын уурхайн тусгай зөвшөөрлийн талбайнууд.....	3
Хүснэгт 2 Төслийн талбайн булангын цэгийн солбицол.....	3
Хүснэгт 3 Үйлдвэрийн нөөц.....	13
Хүснэгт 4 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал.....	19
Хүснэгт 5 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	20
Хүснэгт 6 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	26
Хүснэгт 7 Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө.....	27
Хүснэгт 8 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	31
Хүснэгт 9 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	35
Хүснэгт 10 Удирдлага зохион байгуулалтын хэмжээнд хийгдэх ажлын төлөвлөгөө.....	37
Хүснэгт 11 БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь.....	38
Хүснэгт 12 2023 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	39
Хүснэгт 13 Уурхайн агаар, хөрсний шинжилгээний цэгийн байршил, солбицолууд.....	43

#### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1 Уулын Баяжуулах Таяннуур Үйлдвэрийн байршил.....	4
Зураг 2 Ажилтнуудын амрах байр .....	5
Зураг 3 Нефтийн агуулах.....	6
Зураг 4 “Майн Бласт” ХХК-ийн тэсрэх бодисын агуулах.....	7
Зураг 5. Засварын нэгдсэнгазар.....	7
Зураг 6 Бургастайн хилийн боомт дахь баяжмал буулгах талбай.....	8
Зураг 7 Дизель цахилгаан станц.....	9
Зураг 8 а. Бууртын худаг, б. Уурхайгаас 15км-н худаг.....	9
Зураг 9 Баяжуулах 6-р үйлдвэр.....	16
Зураг 10 Тээвэрлэлтийн хатуу хучилттай автозам.....	16
Зураг 11 Таяннуур уурхайн 2023 оны хөрсний хяналт шинжилгээний тогтсон цэгүүд.....	41
Зураг 12 Таяннуур уурхайн 2023 оны агаарын хяналт шинжилгээний тогтсон цэгүүд.....	42

#### ТОВЧИЛСОН ҮГ

УБТҮ	-Уулын Баяжуулах Таяннуур Үйлдвэр
БОМТ	-Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
СХЗГ	-Стандартчилал, Хэмжил Зүйн Газар
ШУА	-Шинжлэх Ухааны Академи
ГГХ	-Газарзүй-Геологийн хүрээлэн
ЭМААБО	-Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчин
КААХ	- Кемп аж ахуйн хэлтэс

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Төслийн нэр

“Таян нуур” төмрийн хүдэр болон гантигжсан шохойн чулууны ордыг ил аргаар ашиглах төсөл

### 1.2 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:

“Алтайн хүдэр” ХХК

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: **9019032110**

Регистрийн дугаар: **5095549**

Бүртгүүлсэн огноо: 2013.06.19

Хаяг: УБ хот, СБДүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-8, БНБУ-н ЭСЯ-ны байр.

Утас: 88106967, 88623493

### 1.3 Төслийн зорилго:

Тус төслийн зорилго нь Говь-Алтай аймгийн Цээл сумын нутаг дэвсгэрт орших “Таян нуур-1” хэмээх төмрийн хүдрийн болон гантигжсан шохойн чулууны ордод ашиглалт явуулснаар магнетитын хүдрийг олборлож баяжуулан сайн чанарын төмрийн баяжмалыг гадаад зах зээлд нийлүүлж, борлуулахад чиглэнэ.

### 1.4 Төслийн талбайн байршил:

“Алтайн хүдэр” ХХК нь 2009 оноос эхлэн ашигт малтмал ашиглах MV-013527, MV-015377, MV-017626, MV-017627 тусгай зөвшөөрөл бүхий “Таян нуур” төмрийн хүдрийн ордод үйл ажиллагааг явуулж байна. Тус орд нь засаг захиргааны хувиарлалтаар Говь-Алтай аймгийн Цээл сумын нутагт хамаарагдах бөгөөд Бага Таянгийн нурууны хойд талд Улаанбаатар хотоос баруун тийш 1300 км, Говь-Алтай аймгийн төв Алтай хотоос баруун ургаш 168 км, Цээл сумын төвөөс баруун тийш 18 км зайд байрлана.


Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нийт 168.9 га байна.

### Хүснэгт 1. Таяннуурын уурхайн тусгай зөвшөөрлийн талбайнууд

№	Тусгай зөвшөөрлийн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Талбай, га	Хүчинтэй хугацаа
1.	Таяннуур	МУ-013527	45.0	2038.04.10
2.	Таяннуур-1	МУ-015377	123.9	2039.12.28

### Хүснэгт 2. Төслийн талбайн булангын цэгийн солбицол

д/д	Уртраг			Өргөрөг		
	Град	Мин	Сек	Град	Мин	Сек
1	95°	38'	32.02"	45°	33'	1.49"
2	95°	38'	32.02"	45°	33'	29.57"
3	95°	38'	8.25"	45°	33'	29.57"
4	95°	38'	8.25"	45°	33'	1.49"



Зураг 1. Уулын Баяжуулах Таяннуур Үйлдвэрийн байршил.

### 1.5 Ордын үйлдвэрлэлийн нөөц:

“Алтайн хүдэр” ХХК нь 2009 онд Таяннуурын төмрийн хүдрийн ордын төв Т-1 хүдрийн биет дээр нарийвчилсан хайгуулын ажил явуулж нөөцийг өсгөн (А) зэргээр 21,341.5 мян.тн, (В) зэргээр 29,467.1 мян.тн, (С) зэргээр 37,286 мян.тн нийт нийт (А+В+С) зэргээр 88,094.6 тн хүдрийг ЭБМЗ-ийн 2009 оны 10-р сарын -1 ний өдрийн 23-03 тоот дүгнэлтээр Монгол улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

Таяннуурын төмрийн хүдрийн болон гантигжсан шохойн чулууны орд олборлох, боловсруулах төслийн тодотгол ТЭЗҮ хийгдэж 2017 оны 11-р сарын 24-ны өдрийн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын Т/120 тоот тушаалаар батлагдсан. Төслийн Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлтийг “ЭХМОНГОЛ БАЙГАЛЬ” ХХК-аар “Таяннуурын төмрийн хүдэр, гантигжсан шохойн чулууны ордыг ил аргаар ашиглах” төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2018.01.08-ны өдрийн 13/135 тоот албан тоотгоор баталгаажуулсан.

### 1.6 Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц:

“Таяннуурын төмрийн хүдрийг ашиглах” төслийн лицензийн талбайн барилга байгууламж, ерөнхийдөө баруун, баруун хойно, хэсэгт объектууд нь байрладаг болно. Үүнд:

- Уурхайн тосгон / кемп /
- Түлшний агуулах болон шатахуун түгээх станц
- Тэсрэх бодисын агуулах
- Эрчим хүчний станц
- Баяжуулах үйлдвэрүүд
- Машин механизмын засварын газар

- Автопүү
- Хөрөнгийн агуулах SB хашаа
- Гэрээт тээврийн компаниудын кемп
- Харуул, хамгаалалтын байрууд г.м объектууд хамаарна.

**Уурхайн суурин:**

Уурхайн тосгон ил уурхайгаас 5.3 км зайд 13 га талбайг эзлэн байрлана.

Тосгон нь 500 хүний багтаамжтай 1 давхар байр 4 ширхэг мөн 600 хүний багтаамжтай 2 давхар ажилтны байр, ажилтны оффисийн 2 давхар байр, уурын зуух, химийн лабораторын байр гэх мэт бүрэн цутгамал, халуун хүйтэн ус болон халаалттай ажилтнуудыг тав тухтай байдлыг бүрэн хангасан барилга байгууламжуудаас бүрдэнэ. Мөн нэг дор 15 хүн хүлээн авах хүчин чадалтай зочид буудал, халуун ус, угаалгын газар, нийтийн ариун цэврийн газар, хоолны газар, хүнс нарийн боовны цех, уурын зуух, суудлын автомашины гараж, хүнс болон аж ахуйн агуулах, спорт, чөлөөт цаг өнгөрүүлэх байгууламж, харуулын байр зэрэг байгууламжаас бүрдэнэ.



Зураг 2. Ажилтнуудын амрах байр

**Цэвэрлэх байгууламж:**

Уурхайн хотхонд хоногт 300 м<sup>3</sup> бохир ус цэвэрлэх хүчин чадал бүхий бохир ус цэвэрлэх байгууламжийн ажлын дуусган 2013 оны 10 сарын 25-ний өдөр барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс хүлээн авсан.

**Түлшний агуулах:**

Түлшний агуулах нь уурхайн хотхоноос 3,0 км, уурхайгаас 2,4 км алсдан байрлана. Түлшний агуулахад 25 м<sup>3</sup> багтаамжтай бензиний 2 ширхэг, дизель түлшний 50 м<sup>3</sup> 9 ширхэг, аваарын 10 м<sup>3</sup> 1 ширхэг, галын усан сангийн зориулалттай 50 м<sup>3</sup> 2 ширхэг, нийтдээ 14 хадгалах сав1 байна. Дизель түлш түгээх 2 ширхэг, бинзен түгээх 2 ширхэг, нийт 4 ширхэг түгээгүүртэй. Эдгээр нь тус бүрдээ хамгаалах клапан болон шүүлтүүртэй байна. Үүнээс гадна ачиж буулгах байгууламжтай бөгөөд агуулын бүх угсралт, холболтыг зураг төсөл, технологийн шаардлагын дагуу гүйцэтгэсэн. Ачих болон цэнэглэх (автозаправщикт) байгууламжид 1 микрон хүртэл шүүх чадвартай шүүлтүүрийн системийг суурилуулсан. Мөн түлш ачих, буулгах хэсэгт гал унтраах хэрэгслүүд байрлана. Түлш асгарч хөрсийг бохирдуулахаас сэргийлж автомашин цэнэглэх талбайг хатуу хучилттайгаар хийж өгнө. Савнуудын болон түгээгүүрүүдийн худгийг металл хийцээр хийж газрын хөрсөнд газрын тосны бүтээгдэхүүн асгарч алдагдахаас бүрэн хамгаалсан. Мөн 4 ширхэг 21 метрийн өндөртэй аянга зайлуулагч шон, агуулахын бүх объектуудыг холбосон газардуулгын систем, гэрэлтүүлэг, тосны агуулах, операторын байр, харуулын байр, насосны станцын

байр зэргийг мөн зураг төслийн дагуу хийж гүйцэтгэсэн болно. Агуулахыг өргөтгөсөн ба ажлын хүрээнд 50 м<sup>3</sup> 9-н ширхэг савыг барьж эхлэсэн бөгөөд 2012 оны эхэнд ашиглалтанд оруулан ашиглаж байна.



Зураг 3. Нефтийн агуулах

#### **Тэсрэх материалын агуулах:**

Үйлдвэр нь уурхайн талбайгаас зүүн тийш 3,75 км зайд 3 га талбайд тэсрэх материалын агуулах 2 байрлана. Агуулах нь үер усны шуудуугаар хамгаалагдсан төмөр торон хашаагаар хүрээлэгдсэн талбайд байрлах ба гэрэлтүүлэг, харуулын байртай. Агуулахыг тойруулан хамгаалалтын шороон далан байгуулж, аянга зайлуулагчаар зураг төслийн дагуу тоногдсон. Тэсрэх материалын агуулахад 40 тоннын багтаамжтай тэсрэх бодисын стандартын дагуу тоногдсон 21 чингэлэг, гал унтраах хэрэгсэл, усны нөөцлүүр сав байрлана. “Майн Бласт” ХХК нь “Алтайн хүдэр” ХХК-ний Таяннуурын уурхайг тэсрэх материалаар хангах зорилготой “Алтайн хүдэр” салбарт эмульсийн тэсрэх бодис, энгийн тэсрэх бодис гэсэн 2 төрлийн тэсрэх материал үйлдвэрлэдэг үйлдвэрийн тэсрэх бодис, тэсрэх хэрэгсэлийн 120 тн-ийн агуулах, түүхий эдийн 420 тн-ийн агуулахыг ашиглаж байна. Уг үйлдвэр нь энгийн тэсрэх бодисыг жилд 21000 тн, эмульсийн тэсрэх бодисыг 16000 тн үйлдвэрлэх хүчин чадалтай ба уурхайн цооног цэнэглэх ажиллагаан дээр цооног цэнэглэгч эмульсийн 1, энгийн тэсрэх бодисын хоёр автомашин ажилладаг.

#### **Засвар механикийн барилга байгууламж:**

Таяннуурын уурхайн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг уурхайн талбайд байрлах засварын цехэд хийж гүйцэтгэнэ. Засварын цех нь 7.5 га талбайд уурхайгаас 2 км, баяжуулах үйлдвэрээс баруун тийш 1.3 км-т байрлана. Засварын цех нь дугуй засвар, гагнуур, кран, компрессорын станц, токерын цех, хүнд механизмын гэх мэт олон талт иж бүрэн хэсгүүдээс бүрдэнэ. Засварын цехд уулын хүнд механизм болон тээврийн машин, сэлбэгийн агуулах гэсэн 3 хэсгээс бүрдэнэ. Засварын цехыг уурын зуухны халаалтаар халаах бөгөөд өвлийн улиралд ажилчдын ажиллах тайтай дулаан нөхцөлийг бүрэн хангасан орчинтой юм.



Зураг 4. “Майн Бласт” ХХК-ийн тэсрэх бодисын агуулах



Зураг 5. Засварын нэгдсэн газар

**Улсын хил дээрх дамжуулан ачих байгууламж, объект:**

Монгол улсын шинэ Бургастайн боомт нь Таяннуурын уурхайгаас баруун урагш 168км-д Говь-Алтай аймгийн Бугат суманд оршино. Бургастайн боомт нь шалган нэвтрүүлэх /гааль/, Таяннуураас тээвэрлэж авчирсан баяжмалаа боомт дээрх гаалийн талбайд буулгана. Уг талбайд баяжмал хадгалах талбай, гаалийн ажилчидын байр диспетчерийн болон ажилчдын тосгон, хоолны газар, пүү, дугуй засвар, машин парклах талбай зэрэг байгууламжуудаас бүрдэнэ





Зураг 6. Бургастайн хилийн боомт дахь баяжмал буулгах талбай

## 1.7 Дэд бүтэц:

### 1.7.1 Зам харилцаа:

“Таяннуурын төмрийн хүдрийн орд” нь дэд бүтэц зам харилцаа харьцангуй сулавтар хөгжсөн, ундны болон үйлдвэрлэлийн усан хангамж муутай, цахилгаан эрчим хүчний төвийн шугам сүлжээнээс алслагдсан бүс нутагт оршино.

Зам харилцааны хувьд Улаанбаатар- Говь-Алтай аймаг хүртэл хатуу хучилттай болон сайжруулсан шороон замаар зорчино. Сум аймгийн төвүүдийг холбосон шороон замуудтай, төслийн талбай хүртэл авто тээвэр зорчино. Төслийн талбайгаас Бургастай боомт хүртэлх 168.3 км замын 100.0 км-г нь цемент бетон хатуу хучилттай болгох ажлыг “Алтайн Хүдэр” ХХК өөрийн хөрөнгөөр гүйцэтгэж ашиглалтанд оруулаад байна. Цаашид уг замыг шат дараалалтай үргэлжлүүлэн барьж дуусгах төлөвлөгөөтэй байна .

**Үйлдвэрийн зам:** Таяннуурын уурхайн барилга байгууламжууд хоорондоо автозамаар холбогдсон. Уурхайгаас хөрсний овоолгууд, баяжуулах үйлдвэрийн талбай, хүдрийн агуулахууд болон бусад объектуудыг холбосон сайжруулсан замын даланг уурхайн хөрс хуулалтаас гарсан хөрсөөр хийгдсэн ба технологийн тээврийн зам нь 18м өргөнтэй нийт 3.7 км хийгдсэн. Замын суурь нь 1.45 м зузаан, 0,15 метр хайрган хучилттай бөгөөд цаг агаарын байдалд тэсвэртэй, ус урсах боломжтой. 120 хүртэл тонны даацтай тээврийн хэрэгслүүд явахад зориулагдсан байдаг.

**Зам усалгаа:** Олборлолтын үед хуримтлагдсан уурхайн ан цавшлын усыг зүүмп үүсгэн 60м<sup>3</sup>/цаг-ийн хүчин чадалтай насосоор соруулан, МТ86 30тн-ын автосамосвалуудаар өдөрт 6-7 рейс хийж технологийн зам талбайн тоос дарах, ногоон байгууламж услах зэрэгт ашиглана. Тоосжилт дарах, ногоон байгууламжийг услах ажил 3,4,5,6,7,8,9,10-аар саруудад хийгдэх ба жилдээ 12,9 мян.тн ус хэрэглэх юм. Хүйтний улиралд хөрсний температур 0 градусаас бага учир усалгаа хийхэд аюлгүй ажиллагаа талаасаа боломжгүй, уурхайн карьерын ул хэсгийн чулуулаг дээрх температур хасах градусруу орох үед ан цавын усны гаралт нь эрс багасаж, хүйтний улиралд /11, 12, 1, 2 сард/ ус гаралт бүрэн зогсоно.

### 1.7.2 Харилцаа холбоо:

Холбоо харилцааны хувьд уурхай нь “Мобиком”-ын сүлжээ, олон сувгийн сансарын антен, интернетийн сүлжээ, уурхай, баяжуулах үйлдвэр, засварын газар, гадаад тээврийн хэсэг гэх мэт үндсэн хэлтэс тус бүр богино долгионы сувагтай, радио станциар хангагдсан. “Мобиком”-ын сүлжээ 2017 онд сүлжээний өргөтгөлийг хийж 3G сүлжээ оруулсан.

### 1.7.3 Цахилгаан хангамж:

Таяннуурын уурхайн үйл ажиллагааны цахилгаан эрчим хүчийг дизель станцаар хангаж ажиллахын тулд САММИНС маркын 600 кВ –ийн 11 дизель генератор, MTU маркын 1600 кв-ийн 3 дизель генератортой нийт 11600 кВ суурилагдсан чадлаар 0,4 кВ хүчдлийг 10 кВ хүчдэл болгон хувиргах хүчний трансформаторууд 2000 кВ чадалтай 4, 2500 кВ чадалтай 4, 1600 кВ чадалтай 4, 400 кВ чадалтай 2, гадаа байрлах иж бүрэн дэд өртөө /КТПН/ эрчим хүчийг алс зайд дамжуулах 35 кВ хийцээр баригдсан 10 кВ нийт урт 6,5 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дизель генераторын ажиллагааг орчин үеийн микропроцессорын хамгаалалтай компьютерийн хяналтайгаар баяжуулах үйлдвэр, уурхайн суурин, засварын газруудыг эрчим хүчээр хангах техник эдийн засгийн бүрэн боломжтойгоор 24 цагийн турш тасралтгүй диспетчерийн шуурхай удирдлагаар ханган ажиллана.



Зураг 7. Дизель цахилгаан станц

### 1.7.4 Усан хангамж:

Уурхайн тосгоны унд-ахуйн хэрэгцээний усыг ундны усны стандартыг хангаж буй Бууртын худагас хангадаг бөгөөд тоолуур суурилуулан усны хэрэглээндээ хяналт тавин ажилладаг.



Зураг 8. а. Бууртын худаг, б. Уурхайгаас 15км-н худаг

### 1.8 Ажиллах хүчний тухай мэдээлэл:

“Алтайн Хүдэр” ХХК нь Тогтвортой хөгжлийн тулгуур зарчимд суурилсан хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг баримтлан, үндэсний хэмжээний томоохон уул уурхайн үйлдвэрлэгч болох зорилго тавин амжилттай ажиллаж байна.

“Таяннуурын төмрийн хүдрийн ордыг ашиглах” Уулын баяжуулах үйлдвэр нь зуун хувь үндэсний хөрөнгө оруулалттай бөгөөд Монгол инженер, техникийн ажилтан болон ажилчдаар ажиллах хүчнээ бүрдүүлэн ажиллаж байна. 2023 онд бүрэн хүчин чадлаараа ажиллахад 789 орон тооны ажилтантай ажиллахаар төлөвлөсөн.

Одоо ажиллаж байгаа ажиллах хүчний 30 хувь нь орон нутгийн иргэд байна. Цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн хамтаар орон нутгийн залуучуудыг сургаж, дадлагажуулан ажилд авч ажиллуулах, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах бодлого баримталж байна.

## 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 2.1 Газар зүйн бүс, бүсчлэл:

Таяннуурын төмрийн орд нь газар зүйн байрлалаараа Монгол-Алтайн уулархаг мужийн зүүн урд үргэлжлэл болох Алтайн өвөр говийн хойд уулзварт, хэрчигдэл багатай элэгдэл-хуримтлалын процесст хүчтэй автагдсан, далайн түвшнээс дээш 1800-2100м өндөрт өргөгдсөн намхан толгодорхог гадаргатай Таянгийн хөндийн хойд хэсэгт оршино.

### 2.2 Цаг уур, уур амьсгалын тодорхойлолт:

Ордын талбайн орчин тойрон нь эх газрын эрс тэс, хуурай уур амьсгалтай. Цээл сум болон түүний орчин тойрны цаг уурын элементүүдийн сүүлийн 10 жилийн ажиглалтын дунджаар 9,85 мм хур тунадас унах ба дундаж температур -100С-12, 430С хэмийн хооронд хэлбэлзэнэ. Хамгийн их тунадас 5-8-р сарын хооронд унах ба хамгийн халуун үе нь 7-р сар +380С, хамгийн хүйтэн үе нь 1-р сард -36.20С хүртэл хүйтэрнэ. Гол төлөв баруун, баруун хойноос салхилах бөгөөд салхины дундаж хурд 4.45 м/с, ховор тохиолдолд 28 м/с хүрч байсан байна.

### 2.3 Гадаргын болон газрын доорхи ус:

Ордын талбайн хүрээнд гадаргын ил задгай ус байхгүй. Орд нь хүдэржилтийн 3 бүстэй бөгөөд тус бүр нь 1-2км урт, 15-25м ба 25-350м өргөнтэй. Эдгээр биетүүд Ордвик Силурын цагаан шаргал гантиг, биотитот гнейсийг зүссэн дунд Силурын боржингийн гадаад болон дотоод хил заагт үүссэн скарны биетүүдтэй холбоо бүхий үүсэлтэй. Карбонат чулуулгийн ан цав ихтэй, зарим нэгэн карст үүсгэх боломжтой бөгөөд эдгээр нь газрын доорх усны хуримтлал, урсац үүсгэх нөхцөлтэй.

Ордын хэмжээнд геологийн тогтцын онцлогтой уялдан чөлөөт гадаргуутай ан цавын ус зонхилон тархсан ба агуулагч чулуулгийн бутралын бүс буюу тектоник хагарлыг дагасан ан цавын бүсэд ан цав судлын ус, мөн карстын бүс тодорхой хэмжээгээр тархсан. Ордод хамаарах ан цавын усны тархалт, тэжээгдлийн мужийн хүрээ нь хүдрийн биетийн талбайн нийлбэр урт 6.3 км, өргөн 10-120 м байна. Гүний ус хайгуулын цооногуудад 30 м гүнд ажиглагдсан. Энэ чиглэлээр нарийн судалгаа хийгдээгүй.

Ордын талбайд газрын гүний усны статик нөөцийг 1.15 сая м<sup>3</sup>, уг нөөцөөс тооцогдох

дундаж урсацыг 315.5 м3/ хоног байхаар тооцсон. Нөхөн сэлбэх усны динамик нөөц нь хоногт 72м3/хоног, агаарын тунадаснаас нөхөн сэлбэгдэх хэмжээ 44 м3 хоног бөгөөд хоногийн нийт урсац нь 431.9 м3 /хоног, буюу 5.0 м/с байна.

#### 2.4 Хөрсөн бүрхэвч:

Төсөл хэрэгжиж буй талбай нь цөлөрхөг хээрийн тал хөндийн цайвар бор хөрс зонхилон тархсан байна. Мөн цөлөрхөг хээрийн нам уулс, ухаа гүвээ толгодын сулавтар хөгжилтэй цайвар бор хөрс, цөлөрхөг хээрийн нам уулс ухаа гүвээ толгодын цайвар бор хөрс, цөлөрхөг хээрийн гөлтгөнөгүй давсархаг хөрс, цөлөрхөг хээрийн гуу жалгын бүрдэл хөрстэй.

#### 2.5 Ургамлан нөмрөг:

Төсөл хэрэгжиж буй талбай нь цөлөрхөг хээрийн их бүсийн дэд бүс болох Говийн Алтайн нурууны үргэжлэл-цөлөрхөг хээрийн дэд бүсэд багтдаг бөгөөд говийн (Цөлөрхөг хээрийн) хялгана баглуур харганат, говийн сайрын хялгана, түжгэр баглуурт, цөлөрхөг хээрийн таана-Вунгын харгана говийн хялганат, цөлөрхөг хээрийн Дэрс–улалжит хиагт, цөлөрхөг Шарилж-говь-сайрын хялганат ургамлын бүрдмэлүүдтэй.

#### 2.6 Амьтны аймаг:

Экологийн өвөрмөц тогтоцтой энэ нутагт нүүдлийн шувууд, ургамал болон шавжаар хооллодог ба ичдэг дэлэнтэн амьтад, мэрэгч амьтад, шөнийн идэвхтэй шавж давамгайлна.

#### 2.7 Ордын геологийн тогтоц:

Талбай нь монгол орны региональ судалгааны тектоникийн ангиллаар Монгол Алтайн атираат системийн зүүн урд төгсгөл, өмнөд монголын атираат системийн баруун хэсгийн уулзварт региональ металлогений ангиллаар өмнөт монголын Алтай- Сүхбаатарын бүслүүрт тус тус хамрагдана. Энд монгол орны хожуу каледон-түрүү герциний идэвхжилийн заагт үүссэн ордовик-силурын настай карбонат-терригон гаралтай гантигжсан шохойн чулууны үе ба горизонт агуулсан төрөл бүрийн найрлагатай гнейс маягийн хувирмал талст занарууд, түрүү герциний болон хожуу каледоны орогений үе шатанд үүссэн силурын настай ховдын бүрдэлийн түрүү өрнөлийн габбродиорит, диорит, гранодиорит хожуу өрнөлийн гнейс маягийн боржин, боржиндиорит болон тэдгээрийн сүүлчийн фацийн дэл судлын чулуулгууд, ховдын бүрдлээс арай хожуу буюу түрүү герциний дунд үе шатанд үүссэн доод девоны настай том ширхэгтэй пегматит маягийн плагиоборжингууд тархсан байдаг.

Талбай нь хожуу каледоноос орчин үеийн дөрөвдөгч хүртэл цаг үеийг дамжин хөгжсөн нилээд нийлмэл геологийн тогтоцтой юм. Тектоникийн хувьд Өмнөд монгол, Төв монголын атираат системийг заагласан өргөрөгийн дагуу суналтай өмнөт “Их богдын” гүний хагарал болон түүний салбар хагаралуудаар зааглагдсан шугаман структуруудыг үүсгэсэн бөгөөд хожим альпийн атираажилтын үе шатанд үүссэн босоо чиглэлийн хагаралуудаар хэрчигдэж зүймэл-блоклог тогтоцтой жижиг структурууд үүссэн байна. Ордовик-силурын настай дунд зузаалгийн карбонаттерриген гаралтай метаморф хурдас, ховдын бүрдэлийн эхний өрнөлийн габбродиорит, диорит, гранодиоритын хил заагийн метасоматит хувирлын үр дүнд бий болсон скарнтай холбоотойгоор Таяннуурын төмрийн орд (бүлэг илрэл) үүссэн байна.

## 2.8 Говь-Алтай аймгийн Цээл сум:

1924 онд Харнууд отгийн захиргааг өөрчилж Хантайшир уулын хошууны харьяанд Бүрэнжаргалан сум гэж нэрлэж байгуулагдаж байснаа 1931 оноос гол усны нэрийг харгалзан Цээл сум гэж нэрлэжээ.

Цээл сум нь Баянгол, Дэрстэй, Бүрэнжаргалан, Жаргалт гэсэн 4 багтай, 2022 оны жилийн эцсээр 585 өрхийн 2113 хүн амьдарч, 165880 толгой мал тоолуулсанаас тэмээ 1478, адуу 4704, үхэр 3430, хонь 38338, ямаа 117930 тоологдсон байна. Сум нь Алтай хотоос 160 км, УБ хотоос 1160 км зайд Монгол Алтайн нурууны салбар уулсын дунд, хойт талаараа Цогт, урд талаараа Алтай, баруун талаараа Төгрөг сумтай тус тус хиллэдэг. 24 цагийн гэрэл цахилгаанаар хангагдсан.

### 3. ҮЙЛДВЭРЛЭЛ, УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ: 2023 оны Уулын ажлын төлөвлөгөө:

Уулын баяжуулах таяннуурын уурхайн 2023 онд нийт 12,270,284 м3 хөрс хуулалт болон 4,498,543 тн хүдэр олборлолт ажил хийж гүйцэтгэнэ.

2023 онд Баяжуулах 5, 6-р үйлдвэр ажиллах бөгөөд үйлдвэрт уурхайн карьераас 4,401,556 буталсан хүдэр болон ядуу агуулагтай хүдрээс 520,922 тн-г нийлүүлж 4,922,479 тн хүдэр боловсруулна.

Уурхайгаас Бургастайн боомт хүртэлх гадаад тээвэр нь 1-р сараас эхлэн тасралтгүй календарь төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдана. Хөрс хуулалт болон хүдэр олборлолтыг ашиглалтын 13527А, 15377А, төв хүдрийн биетийн талбайгаас явуулна.

#### Хүснэгт 3 Үйлдвэрийн нөөц

Үйлдвэрийн нөөц		Ашиглалтын хаягдал, бохирдол		Ашиглалтын нөөц	
Хүдэр, мян.тн	хүдрийн агуулга, %	хаягдал, мян.тн (3%)	бохирдол, мян.тн (5%)	Хүдэр, мян.тн	хүдрийн агуулга, %
<b>4480.56</b>	<b>35.53</b>	<b>134.41</b>	<b>224.02</b>	<b>53759.32</b>	<b>38.78</b>

#### Уурхайн ажиллах ажлын горим :

Жилийн хугацаанд тасралтгүй ажиллагаатай бөгөөд Улсын хэмжээний баяр ёслолоор амарна.

- Жилд 330 хоног
- Сард 27 бүтээлтэй
- Өдөрт 18-20 цаг бүтээлтэй

#### Уурхайн ашиглалтын технологи:

**Өрөмдлөгийн ажил:** 2023 онд Еriroc D60 маркийн 127-152 мм-н диаметртэй өрөм 3 ширхэг, Еriroc D65 маркийн 152 мм-н диаметртэй өрөм 3 ширхэг DML маркийн 171 мм-тэй өрөм 5 ширхэг тус тус ажиллана.

2023 онд нийт хөрсөнд 511,256 уртааш метр, хүдэрт 109,131 уртааш метр нийтдээ 620,387 уртааш метр өрөмдөнө. Дараах уртааш метрээр хөрсөнд 10,730.2 мян.м3 хөрс тэслэгдэж, хүдэрт 1,110.88 мян.м3 хүдэр тэслэгдэнэ.

#### Тэсэлгээний ажил:

2023 онд үйлдвэрлэлийн төлөвлөсөн түвшинд хүрэхийн тулд **11,150,149 м<sup>3</sup>** хөрсөнд 124 удаа, **1,110,883.39 м<sup>3</sup>** хүдэрт 49 удаа тэсэлгээ хийх шаардлагатай. Тэсэлгээний ажил нь сард дунджаар 14 удаа, жилд 173 удаа тэсэлгээний ажил хийгдэх ба нэг удаад 61 тонн, сард 917 орчим тонн тэсрэх бодис хэрэглэнэ.

Тэсрэх бодисын хувийн зарцуулалт хүдэрт 1.36 кг/м<sup>3</sup>, хөрсөнд 0.67 кг/м<sup>3</sup> байна. Тэсэлгээ хийх хөрс болон хүдрийн доголын өндөр 10 метр байх ба цооног болон эгнээ хооронд Реле РП-Д 45-100мс тавина. Тэсэлгээний ажлыг хөрсөнд сетка 3.5x4.0, 4.0x4.5, 5.0x5.0 болон хүдрийн блокт 3.0x3.5 метрийн харьцаатай байна.

Тэсэлгээний ажилд энгийн болон хүч нэмэгдүүлсэн шингэн Эмульс, Анфо-г Син-В системийн тэсэлгээний иж бүрдэл хэрэгсэлтэй хослуулан хэрэглэнэ. NORD маркын 2 цагт 14 мянган килограмм тэсрэх бодис үйлвэрлэн гаргах чадвартай 1 ширхэг машин ашиглаж уурхайг тэсрэх бодисоор хангана. Машинд тосон фаз 6.5%, усан фаз 93.5%-ийн найрлагатай хийж шингэн эмульсийн тэсрэх бодис, порист 94,5%, дизель түлш 5,5%-ийн найрлагатай хийж анфо тэсрэх бодис үйлдвэрлэнэ. Тэсрэх бодисын түүхий эдийг “Бласт” ХХК өөрийн машинаар тээвэрлэнэ. Уурхай дээр 200 тонн тэсрэх бодис үйлдвэрлэх түүхий эд хадгалах ба сард 4 удаа тээвэрлэн уурхайн хэрэгцээг хангана. Тээвэрлэлтэнд 30 тоннын даацтай 6 машин, тэслэх хэрэгслийн тээвэрт 25 тоннын 1 машин тус тус ашиглана. “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-д заасан заалтын дагуу уурхайн 1 сарын хэрэгцээнээс хэтрүүлэхгүйгээр тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тэсрэх материалын агуулахад хадгална.

#### **Ухаж ачих ажиллагаа:**

2023 онд Уулын Баяжуулах Таяннуур үйлдвэр нь Cat 390F маркийн 7 ширхэг урвуу утгуурт, Cat 390D маркийн молодоктой 2 ширхэг, Cat-6020 маркийн экскаватор 1ш, PC-3000 маркийн экскаватор нь 3ш, PC2000 маркийн экскаватор 1ш, PC-5500 экскаватор 1ш тус тус ажиллахаас гадна тухайн үеийн эвдрэл гэмтлээс шалгаалж нөөцөнд Cat 390F болон PC-3000 маркийн тус тус 1ш экскаваторууд ажиллана. Мөн хөрс болон хүдэрт 10 метрийн доголоор ухаж ачих ажлыг хийж гүйцэтгэнэ.

Тээвэрлэлтэнд MT-86 маркын 55 тн-ын даацтай автосамосвал 40 ширхэг, Cat -777 автосамосвал 4 ширхэг HD-1500 18 ширхэг Cat-773 маркийн автосамосвал 3 ширхэг тус тус ажиллана. Экскаваторын ажлын талбай, автосамосвал маневрлах зай талбайг бульдозероор байнга тэгшилж, цэвэрлэн технологийн зам талбайг автогрейдерээр байнга хусаж, ухаж ачих, тээврийн процессуудад саадгүй, жигд ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

#### **Овоолго:**

2023 онд нийтдээ 12,270,284 мян.м3 хөрс хуулна. Хөрсийг баруун болон зүүн, урд хөрсний овоолго гэж төлөвлөгдсөн бөгөөд тухайн хөрс хуулалтын хамгийн ойр талын зайнаас хамааран зөөх бөгөөд Шохойн чулуу, Скарн, Занар гэж ангилан овоолгыг CAT D10, CAT D8, CAT854H гинжит болон дугуйт бульдозеруудыг ашиглан түрэлт, зам засалт, хөмсөг тавилтын ажлыг овоолгын паспортын дагуу хийж гүйцэтгэнэ.

#### **Хүдрийн агуулах:**

Ил уурхайгаас олборлох хүдрийг баяжуулах 2,5,6-аар үйлдвэрийг шууд тэжээж ажиллах ба үйлдвэр хүлээгдэх, баяжуулах үйлдвэрүүдийн төлөвлөгөөт засвартай үед 5,6-аар үйлдвэрийн нөөцийн талбайд хурааж үйлдвэрийн нөөц үүсгэнэ. Үүсгэсэн нөөцийг бульдозероор хэлбэржүүлэн бага хэмжээний хүдрийн овоолго үүсгэж, CAT 390 экскаватор MT-86 автосамосвалын хослолтойгоор үйлдвэрт нийлүүлнэ. Нөөцийн талбайн хэмжээ 4.5га байна.

#### **Хаягдлын сан:**

Баяжуулах үйлдвэрээс гарах хаягдал 4.1 сая.т байна. Төлөвлөгөөт онд 2,5,6-аар үйлдвэр ажиллах ба 20м өндөртэй ярус үүсгэн 2 үеэр хаягдлын хуримтлал (овоолго) үүсгэхэд 10500м<sup>2</sup> талбайг төлөвлөв. Хаягдалыг үйлдвэрийн талбайгаас CAT-988, 980 тус бүр 1 ш, LG-953 6 ш ачигчийг ашиглан Мт-86 автосамосвалаар тээвэрлэн отвалд буулган

САТ-854Н бульдозер ашиглан хэлбэржүүлнэ.

**Тээвэрлэх ажиллагаа:**

Дотоод тээвэрт 100тн даацтай 42ш САТ-777, 55тн даацтай МТ-86 автосамосвал 39ш ажиллах бөгөөд уурхайн хөрс хуулалт болон хүдэр олборлолтонд ажиллуулахаар төлөвлөж байна. Автосамосвал хүдрийг уурхайн гол замаар тээвэрлэж баяжуулах үйлдвэрт хүргэх ба хөрсийг уурхайгаас 1.5-1,8 км зайд байрлах хөрсний гадаад овоолгод хураана. Автосамосвалыг мөн уурхай байгуулалтын үед зам, далан, хаягдлын далан байгуулах зэрэг бусад ажиллагаанд шороо зөөхөд хэрэглэнэ. Тээвэрлэлтийн дундаж зай хүдэрт 2000 м, хөрсөнд 1250 м байна. Ил уурхайд хурдны дээд хэмжээ 50км/ц боловч ажлын нөхцөл дээд хурдаар ажиллах боломжийг хангахгүй. Автосамосвалууд нь бусад хүнд машин механизмаас доод тал нь 3 м зай барьж ажиллана. Замуудад дээд тал нь 10%-ийн налууатай хашлага суваг хийнэ. Замын хөдөлгөөнийг хянах төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. Шаардлагатай газруудад замын тэмдгүүдийг байрлуулна.

**Баяжуулах үйлдвэрийн төлөвлөгөө:**

2023 онд Баяжуулах 5,6-р үйлдвэрүүд тус тус ажиллахаар төлөвлөсөн. Үйлдвэрт доголдол гарсан тохиолдолд нөөцөнд баяжуулах 2-р үйлдвэрийг ажиллуулна.

Баяжуулах 2-р үйлдвэр 200-250 тн/ц хүдэр хүлээн авч бутлан боловсруулж 90-130т/ц баяжмал үйлдвэрлэх боломжтой. Уурхайгаас 500мм хүртэлх бутлагдсан анхдагч хүдрийг хүлээн авч 4 шатны хяналтын шигшилттэй битүү циклээр -3мм хүртэл бутлана. Бутлагдсан хүдрийг соронзон шинж чанар дээр тулгуурлан хуурай соронзон баяжуулалтын технологиор үндсэн болон цэвэрлэгээний гэсэн 2 шаттай баяжуулж 60%-с дээш агуулгатай баяжмал үйлдвэрлэнэ.

Баяжуулах 5-р үйлдвэр нь нэгдсэн удирдлагын системтэй. Бутлах хэсэг Хятад Америкийн хамтарсан TRIO компанид үйлдвэрлэсэн тоног төхөөрөмж суурилагдсан. Ялган ангилах хэсэг нь Австрали, Хятадын хамтарсан EREIZ magnetic компанийн тоног төхөөрөмж суурилагдсан. Удирдлагын PLC-систем суурилагдсан.

Баяжуулах 6-р үйлдвэрийн тоног төхөөрөмж нь Хятад, Америкийн хамтарсан TRIO компанид үйлдвэрлэсэн тоног төхөөрөмж суурилагдсан бөгөөд 750тн/цаг-ийн хүчин чадалтай. Тус үйлдвэрийн тоног төхөөрөмж нь Баяжуулах 5-р үйлдвэртэй адил бөгөөд хацарт бутлуур нь өндөр хүчин чадал бүхий 900мм хүртэлхи ширхэглэлтэй хүдэр хүлээн авах боломжтой том бутлуур суурилагдсан. Мөн ялган ангилах хэсгийн соронзон сеператор нь EREIZ magnetic компанийн Double drum сеператор суурилагдсан.





Зураг 9. Баяжуулах 6-р үйлдвэр

### **Үйлдвэрийн технологи ажиллагаа**

Уурхайгаас Баяжуулах 5-р үйлдвэр 700мм Баяжуулах 6-р үйлдвэр 900мм хүртэл бутлагдсан анхдаг хүдрийг хүлээн авч 5,6-р үйлдвэр 3 шатны хяналтын битүү шигшилттэй битүү циклээр -3мм хүртэл бутална. Бутлагдсан хүдрийг соронзон шинж чанар дээр тулгуурлан хуурай соронзон баяжуулалтын технологиор үндсэн болон цэвэрлэгээний гэсэн 2 шаттай баяжуулж 61%-с дээш агуулгатай баяжмал үйлдвэрлэнэ.

### **Баяжмалын гадаад тээвэрлэлт:**

Бүтээгдэхүүн борлуулалтын цэг болох Монгол улсын хилийн Бургастайн боомт уурхайгаас 168 километр зайд байрлана. " Алтайн хүдэр" ХХК-ийн Тээвэрлэлтийн хэлтэс нь 2023 онд Баяжмал тээвэрлэлтийг 75тн-ын даацтай өөрийн болон түрээсийн нийт 160 ш хүнд даацын тээврийн хэрэгслээр нийт 1,9 сая.тн баяжмал тээвэрлэж ажиллахаар төлөвлөөд байна.

Баяжмалыг уурхайгаас тасралтгүй тээвэрлэж, хуримтлал үүсгэх бөгөөд худалдан авагч тал өөрсдийн тээврийн хэрэгслээр тээвэрлэлт хийн худалдан авдаг. Уурхайгаас баяжмал тээвэрлэх 168 км замын 81 км-г хатуу хучилттай болгож уртасгасан. Үлдсэн 93 км зам нь сайжруулсан шороон замаар тээвэрлэлт хийнэ.



Зураг 10. Тээвэрлэлтийн хатуу хучилттай автозам

#### 4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ:

2019 онд БОННҮнэлгээний нэмэлт тодотголыг “Эх Монголын байгаль” ХХК-аар хийлгэж БОАЖЯамаар хянуулж батлуулсан болно. Энэхүү БОННҮ-ний тодотголд тус төслийг хэрэгжүүлэх явц, технологийн үе шаттуудад дараах сөрөг нөлөөлөл үүснэ гэж тодорхойлсон.

##### 4.1 Агаарын чанар, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Хүдэр олборлох, бутлах, тээвэрлэх үйл ажиллагаа болон уурхайн хаягдлын овоолгуудаас тоос үүснэ.
- Уурхайн тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа, дизель генераторууд, уурхайн кемпийн халаалтын зуух, тээврийн хэрэгслүүдээс агаар бохирдуулагчид ялгарч орчныг бохирдуулах магадлалтай.

##### 4.2 Хөрсөн бүрхэвч түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Төслөөс хөрсөн бүрхэвчид үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь уул уурхайн үйл ажиллагаанаас үүсэлтэй газрын эвдрэл, мөн уурхайн үйл ажиллагааны техник хэрэгсэл, тээврийн нөлөөгөөр хөрсөн бүрхэвч элэгдэх, доройтох болон уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр их хэмжээгээр дэгдэх тоосжилт нь газар дээр бууж, нарийн ширхэгтэй тортогоор хучигдах сөрөг нөлөөлөл юм.

##### 4.3 Газрын гадарга, хэвлий, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Хөрс хуулалтаас газрын гадаргын унаган төрх өөрчлөгдөх.
- Тээвэрлэлтийн үед үүсэх тоос, шорооны улмаас газрын гадарга тоосонд дарагдах, бохирдох.
- Олон салаа зам үүссэнтэй холбоотойгоор газрын гадарга элэгдэлд орох, хэв шинж өөрчлөгдөх.

##### 4.4 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Төслийн орчинд гадаргын урсац байхгүй. Гадаргын болон газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл харьцангуй бага бөгөөд газрын доорхи усны хяналтгүй, зохисгүй хэрэглээ нь газрын доорхи усанд нөлөөлөж болзошгүй.

##### 4.5 Ургамлан нөмрөг түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Машин техник, тэсэлгээний ажлын үеийн нарийн тоосонцор агаарыг бохирдуулж, тоосны хэсэг нь төсөл хэрэгжих талбайн орчинд ургамлан нөмрөг дээр бууж, ургамлын өсөлт, ургацад муу нөлөөтэй төдийгүй түүний хөгжлийн явцыг сааруулах.
- Хүнд машин техник болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг талхлагдаж, халцгай газар нэмэгдэж салхины нөлөөний улмаас ургамал ургах нөхцөл хумигдаж тухайн хэв шинжийн бэлчээрт олон наст үетэн ургамлын тархац хумигдаж, хамхуул, хамхаг зэрэг ургамал түргэн ургана.

##### 4.6 Амьтны аймаг түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Уурхайн олборлолтын улмаас олон салаа зам гарч амьдрах орчин доройтох
- Уурхайн ойр орчимд тохиолдох зэрлэг амьтад үргэн дайжих, амьдрах орчин хуваагдах, нүүдлийн зам хязгаарлагдах зэрэг нөлөөллүүд үүсэх

## 5. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ:

“Алтайн Хүдэр” ХХК нь уурхай, баяжуулах үйлдвэр, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаварыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэргэжүүлэх зарчмыг баримтлан ажиллаж байна.

“Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн дагуу “Эх Монголын байгаль” ХХК нь уг төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2018 онд батлуулсан бөгөөд үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр боловсруулж, шинэчлэн сайжруулахыг зорьж байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилго нь “Таяннуурын төмрийн хүдэр, гантигжсан шохойн чулууны ордыг ашиглах” төслийн баримтлах байгаль орчны бодлого, менежментийг дахин төлөвлөн, сайжруулах байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг шат дараатай хэрэгжүүлэхэд оршино.

Ордын онцлог байдал, хүдрийн биетийн тогтоц зэргээс хамаарч уурхайн ахилт эгц доошоо чиглэлтэй байгаагаас 2023 онд карьерт техникийн нөхөн сэргээлт хийгдэх боломжгүй юм. Харин шимт хөрсийг хамгаалах, хадгалах зорилгоор 2.0 га талбайг ургамалжуулах биологийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэнэ. Байгаль орчны нөхөн сэргээлтийн 10-аар маягтад шимт хөрсний овоолгийн талбайн солбицолыг оруулсан болно.

### 5.1 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй:

Энэхүү Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд БОННҮнэлгээгээр тогтоогдсон сөрөг нөлөөллийг бууруулах, шимт хөрсний хадгалалт хамгаалалтыг сайжруулах үүднээс биологийн нөхөн сэргээлт хийх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, хог хаягдлын менежмент, удирдлага зохион байгуулалтын зардал, орчны хяналт шинжилгээ хийх зэрэг үндсэн хэсгүүд дэх үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардлыг тооцсон болно. Мөн байгаль хамгаалах зарим нэг урьдчилан тооцоолох боломжгүй зардлыг үйл ажиллагааны болон үйлдвэрлэлийн зардалд тухай бүр нь тусгаж ажиллана.

Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын зардалд нийт Есөн сая есөн зуун наян мянга (9,980,000) төгрөг төсөвлөлөө.

#### Хүснэгт 4. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

№	Бүрэлдэхүүн хэсгүүд	Төсөв./төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,430,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	3,000,000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	1,000,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-

5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	-
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	2,050,000
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	500,000
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,500,000
10	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг олон нийтэд тайлагнах хуваарь	500,000
	Нийт:	9,980,000

## 6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:

Энэхүү төлөвлөгөөнд байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчин буюу агаарын чанар, газрын гадарга болон хэвлий, усан орчин, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг зэрэг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр нь авч үзэн сөрөг нөлөөллийг бууруулах ажил, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан.

